

## Оюуны хөгжил-IQ Сэтгэн бодохуй-TS хичээл

**Сэтгэх чадвар хөгжүүлэх хөтөлбөр**

2020-2021 оны хичээлийн жил



## 1. Танилцуулга

### Оюуны чадварын IQ төв

Оюуны чадварын IQ төв нь нийгэмд оюун ухааныг эрхэмлэх үзлийг дэлгэрүүлэх, сэтгэх чадвар хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах, иргэдийн оюуны хөгжлийг дэмжих зоригтойгоор 2001 оноос хойш үйл ажиллагаа явуулж байгаа боловсрол, шинжлэх ухааны байгууллага.

Бид

- ✓ Цэцэрлэг, ЕБС-ийн сурагчдад зориулсан “Оюуны хөгжил-IQ”, “Сэтгэн бодохуй-TS” цогц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- ✓ Оюун ухаан, сэтгэлгээний чиглэлээр төрөл бүрийн номуудыг эрхлэн гаргах
- ✓ Багш нарт зориулсан “Багшийн хөгжил-TD” сургалтыг зохион байгуулах
- ✓ БШУЯ-ны Улсын сэтгэх чадварын олимпиадыг зохион байгуулах хорооны үйл ажиллагааг хариуцах
- ✓ Сэтгэх чадварын үндэсний үнэлгээ зохион байгуулах
- ✓ Хүний нөөцийн сонгон шалгаруулалтад зориулсан сорил боловсруулах
- ✓ Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх зэрэг чиглэлүүдээр үйл

ажиллагаагаа тасралтгүй явуулж буй, 20 жилийн туршлагатай мэргэжлийн байгууллага юм.

### Яагаад танин мэдэхүйн өндөр чадварыг эзэмших хэрэгтэй вэ?

Өнөөдөр ажлын байранд өргөн ашиглагдах асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээ, тунгаан бодох сэтгэлгээ, багаар ажиллах,.. шилжих хөрвөх чадварыг өндөр түвшинд хөгжүүлэх хэрэгцээ бий болов. Эдгээр чадварыг дан ганц сургуульд суралцах замаар гэхээсээ бие даасан, албан бус, нэмэлт сургалтын аргаар хялбар эзэмшихийг мэргэжил бүхэн шаардаж байна.

Цаашид танин мэдэхүйн доод эрэмбэд хамаардаг чадварууд нь мөдхөн хиймэл оюуны анхдагч үйлдэл болно. Иймд оюун ухаан, сэтгэх чадварт төвлөрсөн, хамтрах, уян зөөлөн, шилжиж хөрвөх чанартай, дээд эрэмбийн чадварыг хөгжүүлдэг боловсрол эзэмших нь онц чухал.

## 2. “Оюуны хөгжил-IQ” хичээл

“Оюуны хөгжил-IQ” нь цэцэрлэг болон бага ангийн сурагчдад зориулсан 8 түвшин бүхий хичээлүүд юм. Хөтөлбөр нь сэтгэхүйн үндсэн үйлээс эхлээд логик, тунгаан бодох зэрэг оюун сэтгэлгээний чадваруудыг төрөл бүрийн дасгал, бодлого, багийн ажил, тоглоомоор системтэй хөгжүүлнэ.

Анги тус бүрээр 48 цагийн хөтөлбөртэй. Оюуны хөгжил-IQ хичээл нь таны хүүхдийн бусад хичээл, асуудал шийдвэрлэх чадварт эерэг нөлөө үзүүлнэ.

### Шалгарсан хөтөлбөр

Дэлхий нийтийн боловсролын тэргүүний зорилго нь шинэ зууны иргэдээс оюуны өндөр чадавхтай, асуудал шийдэх, шийдвэр гаргах чадвар бүхий бүтээлч сэтгэлгээтэй, тасралтгүй суралцагч байхыг шаардаж байна. Хүүхдэд эдгээр чадваруудыг тусгайлсан хөтөлбөр, сургалтаар хөгжүүлэн төлөвшүүлэх нь илүү үр дүнтэйг “Оюуны хөгжил” хичээлийн 20 жилийн судалгаа, туршлага, олон улсын практик харуулж байна.

Оюун сэтгэлгээг хөгжүүлэх тусгайлсан хөтөлбөр нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон агуулгатай, хоорондоо нягт уялдаатай түвшин бүхий хичээлүүдээс бүрддэг.

### Сургалтын цогц хэрэглэгдэхүүн

2-5 настай багачуудад зориулсан хичээлүүд нь үндсэн сурах бичиг болон дасгал ажлын дагалдах 4 номоос бүрддэг. “Оюуны хөгжил, 2-5 нас” хичээлийг заах багшид зориулсан арга зүй, зохион байгуулалтын зөвлөмжүүд бүхий багшийн номтой.

I-V ангийн сурагчдад зориулсан “Оюуны хөгжил-IQ” хичээлүүд нь сурах бичиг, сэтгэхүй хөгжүүлэх тоглоом, хавсралт үнэлгээний сорил, багшийн ном, цахим хичээлүүд зэрэг хэрэглэгдэхүүнүүдтэй.

### Насан туршийн чадвар, бодит үр дүн

“Оюуны хөгжил-IQ” хичээлүүдээр хүүхдэд мэдлэг заахаас илүүтэй тэдний амьдралд насан туршид нь хэрэг болох сэтгэн бодох, асуудал шийдвэрлэх, гүнзгий тунгаан бодох, хамтран ажиллах зэрэг нэн чухал чадваруудыг эзэмшүүлдэг. Эдгээр чадварууд нь шилжиж хөрвөх чадвартай, уян хатан, бүтээлч байх боломжийг бүрдүүлнэ.

### 3. “Сэтгэн бодохуй–TS” хичээл

Энэ нь ЕБС-ийн VI-IX ангийн сурагчдад зориулсан 4 түвшин бүхий хичээлүүд юм. Сэтгэх чадвар бол хамгийн сайн арга барилыг мэдсэнээр суралцаж, дадлагдаж, сайжруулж болдог дадал дүй юм. “Сэтгэн бодохуй-TS” хичээл нь сурагчдыг сэтгэлгээний төрлүүдтэй танилцуулан цэгцтэй, үр дүнтэй сэтгэн бодох арга барилуудыг эзэмшүүлдэг.

#### Оюуны нөөц боломж – сэтгэн бодох арга барил

“Сэтгэн бодохуй-TS” хичээл нь “Оюуны хөгжил-IQ” хичээлийн шууд үргэлжлэл бөгөөд сурагчдын сэтгэлгээг бие даасан чадварын түвшинд хөгжүүлэхэд чиглэдэг. I-V ангийнханд зориулсан “Оюуны хөгжил-IQ” хичээл нь хүүхдийн оюун ухааны боломжит нөөцийг нээн илрүүлэх, улмаар түүнийг нь хөгжүүлэхэд түлхүү анхаардаг бол “Сэтгэн бодохуй-TS” хичээлээр сэтгэн бодох арга барилд сургах зорилготой.

#### Сургалтын цогц хэрэглэгдэхүүн

Дунд ангийн сурагчдад зориулсан эдгээр хичээлүүд нь түвшин бүрээр сурах бичиг, хавсралт үнэлгээний сорил, багшийн номоос бүрддэг. Мөн I, II түвшний хичээлүүд нь сэтгэхүй хөгжүүлэх биет тоглоомуудтай.

#### Бодит үр дүн, бүх талын дэвшил

Оюуны хөгжил, сэтгэх чадварын хичээлүүд нь сурагчдын оюуныг тэлж, сэтгэлгээний шинэ төрлүүдийг эзэмшүүлдэг бөгөөд энэ нь амжилттай суралцагч, асуудал шийдвэрлэгч байх үндэс болдог.



## 4. “Оюуны хөгжил-IQ”, “Сэтгэн бодохуй-TS” хичээлүүдийн онцлог, давуу талууд

### Агуулгын тогтмол сайжруулалт

Манай төвийн судлаачид дэлхийд тэргүүлэгч улс орнуудын шинэ боловсронгуй арга технологиудыг судалж, өөрсдийн сурах бичиг, хэрэглэгдэхүүн, сургалтын арга зүйгээ байнга шинэчлэн сайжруулдаг.

### Багшийн ном

Арга зүй, зохион байгуулалтын зөвлөмжүүд бүхий багшийн номыг ашигласнаар багш нар үнэт цагаа хэмнэж, хичээлийг үр дүнтэй явуулах боломж бүрдсэн.

### Үнэлгээний сорилууд

Оюуны хөгжил, сэтгэх чадварын хичээлүүдэд хамрагдаж буй сурагчдын ахиц, дэвшлийг оношлох үнэлгээний сорилуудтай.

### Сэтгэхүй хөгжүүлэх тоглоомууд

Тоглоом хүүхдийн сонирхол, сэдлийг өдөөх ач холбогдолтой тул хүүхдийн сэтгэхүй хөгжүүлэх үйлд онцгой ач тустай хэрэгсэл болдог. Оюуны хөгжил, сэтгэх чадварын хичээлүүдэд түвшин бүрд тохирсон биет болон хөдөлгөөнт, хөгжөөнт тоглоомуудыг ашигладаг.

### Бодит үр дүн, сэтгэл ханамж

Хүүхэд бүрийн хөгжил, төлөвшил нь тэдний үндсэн чадвар болох оюуны ерөнхий хөгжлийн дэвсгэр дээр л амилна. “Оюуны хөгжил-IQ” болон “Сэтгэн бодохуй-TS” нь хүүхдийн оюун сэтгэлгээг хөгжүүлэх шинжлэх ухаанч, шалгагдаж батлагдсан шилдэг хичээлүүд юм.

## 5. “Багшийн сургалт”

Манай төвөөс хүүхдийн оюун ухаан, сэтгэх чадварыг хөгжүүлэх цогц хичээлийг орон даяар явуулж, хүүхэд бүрд хүртээмжтэй хүргэх үүднээс сургууль, цэцэрлэгийн багш нарт зориулсан онол, арга зүйн сургалтыг тогтмол зохион байгуулж ирсэн.

### ЕБС–ийн багш нарт зориулсан сургалт

Сургууль, ангидаа “Оюуны хөгжил-IQ”, “Сэтгэн бодохуй-TS” хичээлүүдийг заах сонирхолтой, эсвэл IQ клуб хичээллүүлж байгаа багш нарт зориулсан онол, арга зүйн сургалт. Сургалтад амжилттай хамрагдсан багш нарт эдгээр хичээлийг заах эрхийн сертификат олгодог.

### Бүтээлч багшийн уралдаан

Улсын сэтгэх чадварын олимпиадын үеэр “Бүтээлч багш” шалгаруулах уралдааныг тогтмол зохион байгуулдаг. Энэ нь багш нарын дунд сурагчдын оюуны хөгжил, сэтгэх чадварыг хөгжүүлэхдээ бүтээлч, судалгаа шинжилгээнд суурилсан хандлагыг төлөвшүүлж, тэргүүн туршлагаа хоорондоо солилцох, сургалтыг сайжруулах үйл ажиллагаа юм.

### Цахим хичээл

[www.surgalt.iqcenter.mn](http://www.surgalt.iqcenter.mn)

Зөвлөмж, арга зүй, видео хичээлүүд нь хүүхдийг сурах бичгийн дасгал, бодлогуудыг бие даан судлах болон эцэг эхтэйгээ хамтарч хичээллэхэд зориулагдсан. IQ хичээлийн хөтөлбөрийн дагуу боловсруулсан тул хичээл дээр үзсэнээ бататгахад тусалж, танхимын хичээл үргэлжлэхэд дэмжлэг болно.

**iq** ОЮУНЫ ЧАДВАРЫН ЦУТОВ

**ХИЧЭЭЛЭЭ ТАТАЖ АВАХ БОЛОМЖТОЙ БОЛЛОО!**

**ОЮУНЫ ХӨГЖИЛ**

**СОНГОЛТ:**  
~Хичээл тус бүрээр  
~Бүлэг тус бүрээр  
~Анги тус бүрээр



**ХҮҮХЭД БҮРИЙН ХӨГЖИЛ, ТӨЛӨВШИЛ НЬ  
ОЮУНЫ ЕРӨНХИЙ ХӨГЖЛИЙН СУУРИН ДЭЭР  
БИЙ БОЛДОГ.**

📍 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Жамъян гүний гудамж 12, Гранд оффис төв.

☎ 11-324342, 88089515, 90099515

✉ info@iqcenter.mn

🌐 www.iqcenter.mn

📘 www.facebook.com/IQcenterMongolia/

